

**МОНГОЛЫН БӨӨ МӨРГӨЛИЙН ЕРТӨНЦИЙГ ҮЗЭХ ҮЗЭЛД ГАРСАН
ӨӨРЧЛӨЛТ
(XVI ЗУУНЫ ТӨВӨДИЙН БУДДЫН ШАШИН ОРЖ ИРСНЭЭС ХОЙШИХ
ЖИШЭЭГЭЭР)**

И Сын Хүн, доктор (Ph.D)

Улаанбаатар дээд сургуулийн суурь боловсролын тэнхимийн ахлах багш

Товч утга: Эхийн эрхт ёсны үед Монголд бөө мөргөл үүсжээ. Тэр цагаас хойш монголчуудын уламжлалт шашин шүтлэгийн тогтолцоонд бөө мөргөл гүн гүнзгий нэвтэрчээ.

Гэвч XVI зуунаас хойш Төвөдийн Буддын шашин Монголд хүч түрэн орж ирснээр Монголын бөө мөргөл хямралд орж эхэлжээ. Түүнчлэн Буддын шашны бөө мөргөлтэй зөрчилдөх явцад хавчигдах, эвлэрэх, хүлээн зөвшөөрөгдөх, нэгдэх зэргээр үйл явц өрнөж улмаар бөө мөргөлийн шашны ертөнцийг үзэх үзэлд нөлөөлжээ. Иймд өнөөгийн Монгол бөө мөргөлийн ертөнцийг үзэх үзлийг зөв ойлгохын тулд түүний түүхэн өөрчлөлтийг судлах шаардлагатай.

Судлаач миний бие энэхүү судалгаандаа Монголд бурхны шашин орж ирснээс хойш бөө мөргөлийн ертөнцийг үзэх үзэл хэрхэн өөрчлөгдсөнийг судлахыг зорив. Үүнийг судалснаар шашны мөргөлдөөн ертөнцийг үзэх үзэлд хэрхэн нөлөөлдөг болохыг, ертөнцийг үзэх өөр өөр үзэл хоорондоо хэрхэн зөрчилдөж, мөргөлдөж, улмаар нэгэндээ нөлөөлж болдгийг жишээлэн харуулахыг, Монголын бурхны шашин ба бөө мөргөлийн ертөнцийг үзэх үзлийн ижил төстэй ба ялгаатай талуудыг харьцуулахыг зорив.

Түлхүүр үгс: Монголын бөө мөргөл, Төвөдийн буддын шашин, ертөнцийг үзэх үзэл, бөө, шашин.

Төвөдийн Буддын шашин орж ирсний дараах монголын бөө мөргөлд гарсан хавчлага

XVI зууны сүүлээс Монголын хаад ноёд бурхны шашныг дэмжих болов. Учир нь шашны нэгдлээр улс төрийн нэгдэлд хүрэхийг хүсэж байсан юм. Монголын ноёрхогчид нь энгийн хүмүүсийн дунд тархаж байсан бөө мөргөлийг хавчин саармагжуулах, эвлэрүүлэн орлуулж Төвөдийн Буддын шашныг түгээн дэлгэрүүлэх хоёр том аргыг ашигласан байна.

Бөө мөргөлд гарсан хавчлага хэд хэдэн хэлбэрээр явагдсан бөгөөд эхнийх нь онгодыг устгах явдал байв. Монголын бөө

нар онгоддоо ихээр анхаарал тавьж, түүгээр дамжуулан бөөгийн зан үйлийг хийдэг тул онгод нь бөө нарын тахиж шүтдэг гол зүйл байсан юм. Бурхны шашныг хүлээн зөвшөөрсөн Монголын ноёрхогчид бөөгийн шашныг хуурамч шашин хэмээн үзэж,¹ бөө нарын шүтдэг тэнгэр, онгод тахиыхыг хориглож, бурхны шашны бурхны хөргийг гэртээ залж, бурхны шашны сургаал, тарнийг зааж байжээ.² Бөөгийн тахил, зан үйлд бөөгийн тамлага хэрэглэхийг хориглож, оронд нь бурхны шашны тарни, номыг тараажээ. Эдгээр хатуу арга хэмжээнүүд нь монголчуудын бөө мөргөлийн шашнаасаа татгалзаж, бурхны шашныг хүлээн зөвшөөрөх бодит шалтгаан болжээ.

¹ Бурхны шашныг хүлээн зөвшөөрсөн Монголын ноёрхогчид бөөгийн шашныг жигшиж, харааж, бурхны шашныг ариун, цагаан шашин, бөө мөргөлийг хар шүтлэг, бүдүүлэг шашин гэж нэрлэжээ. (Далай Ц. (2000) Монголын бөөгийн мөргөл, УБ, 30.)

² Хайсиг В. (2003), Монголын шашин, 60.

Монголын ноёрхогч анги хийгээд бурхны шашны лам нар шууд хэлмэгдүүлэхээс гадна эвлэрүүлэн орлуулах аргаар бурхны шашныг дэлгэрүүлж байв. Эвлэрүүлэн орлуулах төлөөллийн арга нь бөө мөргөлийн гол зан үйл, үйл ажиллагааг бурхны шашны илүү боловсронгуй зан үйлээр сольж орлуулах явдал байв. Эхлээд онгод бурхныг Будда, Махгал болгон сольж, Бөөгийн үүргийг мөн лам нар орложээ. Лам нар монголчуудад бурхны шашны “ид шидийн” зан үйл, ном засал нь хүнийг муу ёрын сүнс, гамшгаас хамгаалж, малын халдварт өвчнийг зайлуулж, бие махбодын өвчнийг анагаадаг хэмээн номложээ.

Уг зан үйлийн агуулга нь бөө мөргөлийн тусламжаар диваажин дахь хойд дүрийг сурталчлах зорилготой байсан тул бөө мөргөлийн шашны үзэл санааны хамт бурхны шашны үзэл санааг нэмж, олон нийтэд түгээсэн. Бурхны шашны тарни судрууд нь бөөгүйгээр өөрөө хийж чадахаас гадна бурхны шашны авралын тухай үзлийг төлөвшүүлэхэд тустай байсан тул бөө мөргөлийг орлох ашигтай хэрэглүүр болсон юм.³ Лам нар нь өөрсөд шигээ системтэй мэдлэг олж авахад хүндрэлтэй байсан нүүдэлчдэд хүрдээ эргүүлэх эсвэл маани тарни унших гэх мэт шашны илүү хялбар зан үйл хийх замыг нээж өгсөн.⁴ Лам нар сүм хийдийн боловсрол олгох болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар монголчуудыг бурхны шашинд татжээ.

Монголын ноёрхогч анги болон бурхны шашны эсэргүүцэлтэй тулгарсан монголын бөө нар бурхны шашинд ариун гэж тооцогддог Будда бурхныг магтан алдаршуулсан хэллэгүүдийг зан үйлдээ зориуд нэмж оруулах юм уу, өөрсдийн итгэл үнэмшлээ хадгалахын тулд Төвөдийн тарни номын хэллэгийг ашигладаг байжээ.⁵

Монголын бурхны шашны лам Д.Дэмбэрэл нь “Төвөдийн Буддын шашныг хүлээн зөвшөөрсний жишээ бол бөө нар үхэх гэж буй өвчний төлөө хийдэг зан үйлд сахиус онгодыг дуудаж, онгод бууж ирэхэд хоёр чойжин ламаас үүнийг нотлохыг гуйсан явдал юм” гэжээ.⁶

Тарнийн бясалгалаар оюун санааны хүчийг эзэмшсэн лам нар бөөгийн зан үйлээс гадна гэгээрлийн үйлийг гүйцэтгэдэг байв. Лам нар онгодтой тарниар харьцсанаар олж авсан ид шидийн хүчээрээ эдгээх бөгөөд нарийн ширийн үйлдлээр чөтгөрийг хөөн зайлуулдаг. Эдгээр лам нарын эдгээх, ид шид, чөтгөрийг зайлуулах ур чадвар нь Монголын хаад ноёдыг өөртөө татахад чухал үүрэг гүйцэтгээд зогсохгүй нийт монголчуудын бурхны шашныг шүтэхэд хангалттай шалтаг байв.⁷

Төвөдийн Буддын шашин орж ирсний дараа монголчуудын бөө мөргөлийн талаарх уламлалт шашин шүтлэгт асар их сорилттой тулгарсан бөгөөд үүнээс болж бөө болон түүний онгод шүтээн сүйдсэн байжээ. Бөө мөргөлөө алдсан монголчуудад лам нар нь бурхны шашны зам мөрийг хялбархан хэрэгжүүлж болох ухуулгын аргыг заажээ. Бөөгийн шашнаас илүү хүчтэй сургаалын тогтолцоотой бурхны шашны хавчих, эвлэрүүлэн дэлгэрүүлэх арга барил Монголын тал нутагт илүү тохирч хурдан нөлөөлсөн юм.

Энэхүү хямралын нөхцөлд харын бөө нар Төвөдийн Буддын шашны нөлөөг үгүйсгэж, бөөгийн уламжлалт зан үйлийг баримталдаг байсан ба цөөн тооны бөө нар дуудлагадаа Төвөдийн Буддын шашныг үгүйсгэсэн хэллэгүүдийг оруулсан байжээ. Эдгээрийн нэг жишээг дараах бөөгийн дуудлагаас харж болно.

³ Хайссиг.В. (2003), 82. Чин улсын эзэн хаан Канши бурхны шашныг идэвхтэй дэмжиж, бурхны шашны ном судрыг орчуулан засварлаж, Монголын бүх сүм дугануудад түгээн дэлгэрүүлж байсан ба энэ хугацаанд монгол домгийн элементүүдийг Буддын шашны номнуудад хольж хутгаж байжээ.

⁴ Паг Вон Гил (1998), Умарт нутгийн ард түмний бөө мөргөл ба зан үйл, Улсын угсаатны зүйн төв мүүзэй, 345.

⁵ Паг Хван Ён (2015), *Монголын бөө мөргөл дэх буддын шашныг хүлээн зөвшөөрөх хэлбэрийн судалгаа*, 37.

⁶ Дэмбэрэл Д (2019), Монголын бурхны шашныг хүлээн зөвшөөрсний дараах шашин ба нийгмийн өөрчлөлтийн судалгаа, Зен соёлын судалгаа 27, Солонгос буддын зен судалгааны хүрээлэн, 216-217.

⁷ Хайссиг.В. (2003), 84.

Зул хүжээр зулгуйдсан
Зусар үгээр бялбайсан
Бурхан бурхан гэдэг нь
Будаг шунх хоёр юм.
Лам лам гэдэг нь
Лай ланчиг хоёр юм.⁸

Харин бөө нарын дийлэнх нь бурхны шашны хавчлагын эсрэг бурхны шашны дүрийг шүтэх, бурхны шашны үзэл ойголтуудыг хүлээн авах зэрэг бурхны шашны дайралтад уян хатан хариу үйлдэл үзүүлэхийн зэрэгцээ бөө мөргөлөө хадгалахыг хичээсэн.

Монголын ноёрхогч анги болон бурхны шашны эсэргүүцэлтэй тулгарсан монголын бөө нар өөрсдийн итгэл үнэмшлээ хадгалахын тулд бөөгийн дуудлаганд Төвөдийн бурхан болон бурхан багшийг магтан алдаршуулсан бичвэрүүдийг нэмж оруулах, эсвэл бурхны шашны тарни хэллэгийг тэр хэвээр нь хэрэглэж бурхны шашинтай нэгдэх аргыг эрэлхийлжээ. Ялангуяа бурхны шашны шүтлэгтнүүд, бөөгийн шүтлэгтнүүдтэй гэрлэсэн тоо өссөнөөс болж бөө нар шашин хоорондын эв найрамдлын төлөө тахилгын дуудлагад бурхны шашны үг хэллэгийг нэмж байсан.⁹ Үүнтэй холбоотой дараах нэг жишээ бөөгийн дуудлагад харж байна;

Хорчины шарын бөөгийн дуудлага:
Будлангийн уул минь
Бурхан багш заларсан
Буруу номтой бөө нар манийг
Богдын гэгээн номлосон
Аврагч Арьяабал
Авралдаа авдаг Алтангэрэл
Соёрхогч Зонхов
Соёрхолдоо авдаг судар ном
Зул хүжээ өргөж байна.
Зуугийн гэгээндээ даатгана ...
Бурхан номдоо залбирч байна
Богдын гэгээндээ даатгав.¹⁰

Шарын бөө нар бурхны шашны бурхдыг хүлээн авч, тэдний ертөнцийг үзэх үзэл, мөн бурхны шашны сонирхолтой зан үйлийг хүлээн зөвшөөрч байв. Тэд бөө мөргөл, бурхны шашныг хольж, бөөгийн шашныг гаднын хавчлага, дарамт шахалтаас хамгаалахыг оролдсон. Буриад бөөгийн тахилгын зан үйл болох Чанар тахилгад бөөгийн шашин, бурхны шашин хоёрыг муудалцуулахгүй гэсэн тангараг амлалтыг нэмж оруулсан нь бурхны шашны нөлөөнөөс бөө мөргөлийн ёс заншлаа хадгалан үлдэхийг хүссэн бөө нарын хандлагыг сайн харж болно.¹¹

Иймээс Монголын ихэнх бөө нар бурхны шашны хавчлагыг даван туулахын тулд бурхны шашны гадна хэлбэрийг “өмсөхөөр” болжээ. Бурхны шашныг нэн даруй нэвтрүүлсний дараа Монголын бөө мөргөл нь бурхны шашны ертөнцийг үзэх үзэл, зан үйлийг хэсэгчлэн хүлээн зөвшөөрч, бурхны шашинтай холимог хэлбэрт орж, бөө мөргөлөө хадгалахыг хичээжээ.

Монголын бурхны шашин, бөө мөргөл хоёрын мөргөлдөөнөөс бий болсон өөрчлөлт

Эрдэмтдийн ертөнцийг үзэх үзлийг ангилахад ашигладаг уламжлалт арга бол ертөнцийг үзэх үзлийг бүрдүүлдэг үндсэн үнэт зүйлсийн талаарх асуултын хүрээнд ангилах явдал юм. Аливаа хүн эсвэл бүлгийн ертөнцийг үзэх үзлийг ойлгохын тулд эрдэмтэд ертөнцийг үзэх үзлийг тодорхойлох философийн асуултуудыг боловсруулах замаар ертөнцийг үзэх үзлийг нь ангилсан билээ. Жишээлбэл: “Бурхны мөн чанар, туйлын ахуй гэж юу вэ?”, “Хүн хаанаас ирсэн бэ?”, “Ертөнцийн гарал үүсэл, мөн чанар юу вэ?”, “Үхсэний дараа

⁸ Сүхбат.Ш. (2007), Бөө, 11.

⁹ Бөө нар “Арьяабал ум маани бад ми хум” хэмээх тарни үгийг бөөгийн дуудлагад нэмж уншдаг байжээ. Сүхбат.Ш. (2007), 11.

¹⁰ Сүхбат. Ш. (2007), Бөө, 168-169.

¹¹ Паг Хван Ён (2015), Монголын бөө мөргөл дэх буддын шашныг хүлээн зөвшөөрөх хэлбэрийн судалгаа, 50.

хүнд юу тохиолдох вэ?” гэх мэт асуултауд байна.¹²

Судлаач миний бие Монголын бөө мөргөлийн ертөнцийг үзэх үзэлд гарсан өөрчлөлтийг бурхны тухай, сансар огторгуй(байгаль)-н тухай, мөн хүний сүнс, хойд насны тухай үзэл гэж хувааж судлах болно.

1) Бурхны тухай үзлийн өөрчлөлт

Монголчууд өөрсдийнх нь амьдралд шууд болон шууд бусаар нөлөөлдөг байгалийн үзэгдлийг онгод мэт шүтэж, өвөг дээдсийн сүнс, төрөл бүрийн онгодыг буулган авдаг байжээ. Бөө нар тэнгэрийг хүний амьдрал, байгалийн бүх юмсыг хариуцдаг бурхан хэмээн шүтэж ирсэн юм.¹³ Онгод болон өвөг дээдсийн сүнс ч гэсэн өөрийгөө болон овог аймгаа сахин хамгаалах хүчтэй гэж итгэж шүтсэн. Монголчууд мөн галыг бузар муу явдлыг зайлуулж, гэр бүлийнхээ цог хийморийн бэлгэдэл болгон тахин шүтэж, овог аймгаа хамгаалдаг сүлд хэмээн шүтдэг байжээ.¹⁴

Ийнхүү Монголын бөө мөргөлийн бурхныг үзэх үзэл нь байгалийн бүх үзэгдэл амьтай, сүнстэй, эзэнтэй байдаг пантеист үзэлтэй болон тэнгэр, газар, байгалийг хариуцдаг бурхад байдаг гэж үздэг политеист шашны үзэлд суурилж байв.

Бурхны шашин орж ирснээр бөө мөргөлийн бурхны тухай үзэлд өөрчлөлт гарчээ. Лам нар Монголын уугуул бурхдыг Будда, Бодьсатва болгож, бөө мөргөлийн тахилгын дуудлагыг бурхны шашны тарни дуулал болгон өөрчилжээ. Мөн аман зохиолоор уламжлагдан ирсэн Монголын домог үлгэрт гардаг бурхдын нэрийг Очирваань бурхан, Майдар бурхан, Шагжамүни нарын нэрээр сольж, нэмсэн

юм. Мөн Буддаг “бурхан багш” гэж нэрлэж, бөө мөргөлийн онгодыг мөн бурхны шашных болгон өөрчилжээ.¹⁵

Монголын бөө нар бурхны шашны хавчлагаас зайлсхийхийн тулд онгодын магтаалд бурхны шашны элементүүдийг нэмсэн юм.¹⁶ Бөөгийн шүтдэг тэнгэр, газар, өвөг дээдсийн онгод бурхдыг бурхны шашинтай ижил шинж чанартай бурхдаар сольж, нэмжээ. Монгол бөөгийн “Галын бурхны магтаал”-ыг харвал “Бурхан багш гал асааж, Хурмаст тэнгэр галд шатаалаа” гэсэн өгүүлбэр харагдана. Мөн “Гэгээн Бурхан багшийн бүтээсэн Хурмаст тэнгэрийн гуйсан ёсоор...” гэсэн бөөгийн магтаал байдаг. Үүнийг харвал 33 бурхан болон 99 тэнгэрийн тэргүүн гэгддэг Хурмаст тэнгэрийг Буддатай холбож, бурхныг бөөгийн шүтлэгтэй холихыг оролдсон нь харагдаж байна.¹⁷

Үүний зэрэгцээ монгол бөө мөргөлд “газрын бурхан Этүгэн эх” хэмээх уламжлалт ойлголт бий. Газрын бурхан бол бөө мөргөлийн үндэс болсон анхны объект бөгөөд Монголын уламжлалт харын бөө нар онцгойлон газар дэлхийг ариун дагшин хэмээн үздэг байжээ. Монгол бөө нар газар дэлхийн бурхад гэж газар шороо, ус, уул, өндөрлөг газар, гол мөрөндөө шүтэж байжээ. Харин бурхны шашны нөлөөнөөс болоод бөө мөргөлийн газар усны бурхдад хүж өргөх зан үйлд газар гэсэн утгатай “савдаг”, ус гэсэн утгатай “лус” гэсэн нэрсийг засан нэмж оруулжээ. Вальтер Хайссиг нь Монголын бөөгийн шашны газар дэлхийн онгодыг илэрхийлсэн “лус савдаг” хэмээх нэр томъёог Төвөдийн Буддын шашны тарни, номыг зохиогчид Монголын бөөгийн шашны газар дэлхийн онгодыг бурхны шашныхаар солих явцад хэрэглэсэн гэж хэлжээ.¹⁸ Мөн тэнгэр газрыг

¹² И Сын Хүн (2021), Монголын ертөнцийг үзэх үзэл ба түүний өөрчлөлт, Уб, 18.

¹³ Пүрэв.Отгоны (2014), *Монгол бөөгийн шашин*, 101-117.

¹⁴ Хайссиг.В (2003), 164-165.

¹⁵ И Анна (2010), *Монгол ардын итгэл үнэмлэлийн судалгаа*, Сөүл:Солонгос соёлын пресс, 21-24.

¹⁶ Хайссиг.В. (2003), 106.

¹⁷ Хайссиг.В. (2003), 100-101.

¹⁸ Цэрэнсодном.Д. (2001), 28.

бүтээсэн тухай Монголын домог үлгэрийг харвал Эцэг бурхан “Будда” болон Майдар бурхныг “бүтээгч бурхад”-аар дүрсэлжээ. Мөн Шагжтөв бурхан тэнгэрээс атга шороо барин буун ирж, газар цацаж, газар дэлхийг бүтээсэн хэмээн дүрсэлсэн байдаг. Энэ нь мөн бурхны шашны “бурхдыг нэмж орлуулсан”-ыг харуулж байна.¹⁹

Газар дэлхийг Шагжтүв бурхан бий болгосон гэнэ. Анх газар дэлхий гэж үгүй, нэлээн ус далай байсныг тэнгэрээс чимх шороо авчирч цацаад манай дэлхий бүрэлджээ. Түүн дээр нь өвс ургамал, ан амьтан, хүн бий болов.²⁰

Анхандаа газар байхгүй, гал, ус, салхи хольцолдсон юм байжээ. Тэгээд Бурхан багш шороо авч ус руу хийхэд газар дэлхий буй болж, өвс ургамал, мод бут дэлгэрч гэнэ. Харин дараагаар нь хүн бий болгосон гэнэ.²¹

Монгол бөө нар галын бурхныг элбэг дэлбэг байдлыг тэтгэх, эд баялаг, мал сүргийг хамгаалах үүрэгтэй хэмээн үзэж, галын бурхныг “отгон галын хаан”, “отгон галын хаан эх” гэж дууджээ.²²

Гэвч бурхны шашин нэвтэрсний дараа “отгон галын хаан эх”-ийг “Бурхан багш гал асааж, Хурмаст тэнгэр гал бадраасан” гэж илэрхийлжээ. Үүнээс үзэхэд Бурхны шашны нөлөөгөөр галын бурхны дүр төрх өөрчлөгдөж, ардын бөө мөргөлийн гол үзэл санаа бурхны шашинд дарагдсан үед бурхны шашны бурхдыг хүлээж авах, орлуулах замаар нэгтгэхийг оролдсон нь харагдаж байна.²³

Бөөгийн дуудлагаас дараах нэг жишээг харж болно. Эхнийх нь бөө мөргөлийн гал тахих дуудлага юм. Үүнээс харвал гал голомтыг эцэг эх бий болгосон гэж үзсэнийг харж болно.

99 тэнгэрийн бүтээсэн гал голомт
Есүхэй эзний цахисан гал голомт
Хаан эцгийн цахисан,
Хатан эхийн үлээсэн
Хар чулуун эхт
Хатан төмөр эцэгт
Хаан эцгийн гал голомт.

Харин дараагийнх нь лам нар түүнийг өөртөө тохируулан засаж бурхан гал голомт бий болгосон гэж өөрчилж, бурхныг магтсан үг үсэг оруулжээ.

99 тэнгэрийн бүтээсэн гал голомт
Есүхэй эзний цахисан гал голомт
Хаан эцгийн цахисан гал голомт
Бурхан тэнгэрийн бий болгосон
Буян бүхнийг авчирч
Бузар бүхнийг арилгагч гал голомт²⁴

Бурхны шашин Монголын бөөгийн онгодын мөн чанарыг өөрчилж, онгодын гарал үүсэл, эрх мэдлийг бурхны шашин болон бусад Төвөдийн онгодоор солих, эсвэл ижил төстэй шинж чанартай монгол онгодтой адилтган хольжээ. Хоёр шашныг холих аргыг хэрэглэснээр бөө мөргөлийн бурхны тухайн үзлийг бурхны шашных болгон өөрчлөхийг оролдсон юм. Гэвч бөө мөргөлийн онгодыг Төвөдийн уламжлалт бурхад, бодьсдвагаар орлуулснаар синкрет шинж чанартай байхаас өөр аргагүй болжээ.

Нөгөөтээгүүр, Монголын бөө мөргөл нь хавчлагад өртөхгүйн тулд бурхны шашны бурхдыг онгод шүтээндээ нэмэх, солих зэргээр бөөгийн итгэл үнэмшлийг хадгалахыг оролдсон. Энэ үйл явцад Монголын бөө мөргөлийн бурхны тухай үзэл нь Төвөдийн бурхны шашны бурхдыг одоо байгаа бурхдадаа оруулах шашны синкретизм аргаас зайлсхийж чадалгүй, уламжлалт ертөнцийг үзэх үзлийг өөрчлөхөд хүрчээ.

¹⁹ Цэрэнсодном.Д. (2001), Монголын ардын домог үлгэр, И Пён Лай ор., Тайвон пресс, 28-33.

²⁰ Цэрэнсодном.Д. (2001), 28.

²¹ Цэрэнсодном.Д. (2001), 169.

²² Хайссиг.В. (2003), 210-211.

²³ Хайссиг.В. (2003), 210-211.

²⁴ Далай.Ч. (1959), Монголын бөөгийн мөргөл, Уб, 36-37.

2) Орчлон ертөнц (байгаль)-ийг үзэх үзлийн өөрчлөлт

Монголын бөөгийн орчлон үүссэний тухайд Отгоны Пүрэв “Ертөнц эрт урьд цагт нэгэн цогц эмх замбараагүй юм байгаад дундаас нь гал болоод ертөнцийн бүх юм үүссэн бөгөөд орчлон хорвоо анх нэгэн бүхэл улайдмал зүйл байснаа бие биенээс тасарч салж өнөөдрийнх шиг хэлбэртэй болсон” гэжээ.²⁵ Бөө мөргөлд орчлон ертөнц бол гал хэмээх нэгэн цогц эмх замбараагүй улайдмал зүйл байгаад тасарч салснаар бүх юмсыг амьдруулагч тэнгэр, бүх юмсыг хэлбэр дүрстэй болгосон газар дэлхий бий болсон. Мөн тасарч салах явцад огторгуйн ертөнц, амьд биетүүд дахин бий болсон. Монгол бөө нар тэнгэрийг арга, газрыг билэг гэж бодох бөгөөд, бүх зүйлийн эцэг нь тэнгэр, эх нь газар гэж айлдсан ажээ.²⁶

Харын бөө ертөнцийг дээд, дунд, доод зэрэглэлд хуваадаг бөгөөд ертөнцийг гурван давхаргатай шаталсан ертөнц биш гурван тив гэж үздэг. Төвөдийн өндөрлөгийг дээд давхарга, Төв Евразийг тал хээрийг дунд давхарга, томоохон голуудын сав газрыг доод давхарга гэж боддог бөгөөд гурван тивд хүн, амьд биетүүд тус тус оршин суудаг гэж үздэг. Иймээс Харын бөө гурван ертөнц(тив)-ийг чанарын хувьд өөр давхарга гэхээсээ илүү өндөр нам тивийн ялгаа гэж үздэг байв.²⁷

Харын бөө ертөнцийг нарт хорвоо, харанхуйн орон гэж хоёр хуваасан бөгөөд нарт хорвоо нь гэрэлтэй, цаг хугацаа хязгаарлагдмал, тоос шороо оршдог газар юм. Амьд хүмүүс ба амьтад бол ертөнц, харанхуйн орон бол хүний нүдэнд үл үзэгдэх газар бөгөөд үхэгсдийн сүнс очдог ертөнц юм. Харанхуйн орон бол ямар ч зорилго, талархал, баяр баясгалан, гоо үзэсгэлэн, амьдралгүй хоосон орон зай

учраас бурхны шашинд байдаг хойд насны тухай ойлголт байхгүй.²⁸

Харанхуйн орон жирийн хүмүүст үл үзэгдэх боловч бөө хүн энэ ертөнцийг хардаг юм. Бөө хүн шашны зан үйлээр дамжуулан онгодын хүчийг хүлээн авахдаа харанхуйн орныг зорин очиж онгод сүнстэй уулзаж нарт хорвоод байгаа хүмүүсийн хүслийг дамжуулж, уг хариулт эсвэл зөвлөгөөг хүлээн авч, хүмүүст дамжуулж болно. Ийнхүү харанхуйн орны онгод сүснүүд бөө нараар дамжуулан гэрэлт хорвоод нөлөөлж болох бөгөөд эд нар нь дэлхийн бүх амьтан, ургамал, хүн, уул ус, гол мөрөн, нуур, мод, чулууг халамжлан хамгаалдаг.²⁹ Гэрэлт хорвоо бол онгод болон тэнгэр хоёрынхоо буянаар асуудлыг шийдэж, байгальд эв найрамдалтай байж амар амгалан, аз жаргалыг эдлэх амьд амьтдын ертөнц юм. Нарт хорвоо нь тэнгэр ус, амийг бүтээж, газар дэлхийгээ баяжуулж, бүх зүйлийг өөрийн онцлогт тохируулан оршин тогтнохын тулд хамгаална.

Харын бөөгийн ертөнцийг үзэх үзэлд шүүн шийдэгч байдаггүй бөгөөд нарт болон харанхуй ертөнц гэж хуваадаг. Онгодын хүчийг авсан бөө, онгод сүнснүүдээс бусад нь нарт болон харанхуйн ертөнцийн хооронд харьцаж чадахгүй. Мөн энэ ертөнцийн тэнгэр, газар, ус гээд бүхий л оронд онгод сүнс оршдог ба эдгээр онгодод буруу зүйл хийвэл тухайн хүн зовлонтой болдог. Энэ тохиолдолд бөө нар онгодыг тайвшруулан аргадах зан үйл хийдэг ажээ.³⁰

Төвөдийн Буддын шашин нэвтэрснээр орчлон ертөнцийг үзэх үзэл өөрчлөгджээ. Нэгдүгээрт, ертөнц бий болсон гарал үүслийн талаар “Төвөдийн бурхад ертөнцийг бүтээсэн” гэж өөрчлөгдсөн. Монголын ертөнцийг

²⁵ Пүрэв.Отгоны (2001), *Монголын бөөгийн шашны ерөнхий шинж чанар*, Монголын бөө мөргөл ба угсаатны зүй, Уолин пресс, 26.

²⁶ Пүрэв.О. (2014), 69-70.

²⁷ Пүрэв.О. (2014), 73-81.

²⁸ Пүрэв.О. (2014), 81-82.

²⁹ Пүрэв.О. (2014), 118-119.

³⁰ Пүрэв.Отгоны (2001), 26.

бүтээсэн тухайн домог үлгэрийг харвал Эцэг бурхан, Очирваань, Майдар бурхан нар хорвоо ертөнцийг бүтээхэд хамтран ажиллаж байсныг харуулж байна.³¹

Эрт дээр үед энэ ертөнцөд живх байхгүй байсан бөгөөд бүхэлдээ том усаар бүрхэгдсэн байв. Шигмүни бурхан, Майдар бурхан, Эцэг бурхан нар хамтдаа дэлхийг бүтээхээр усан дээгүүр явж байв. гурван бурхан усан дээр шороо, элс цацаж дэлхийг бүтээж, дээр нь мод, мөчир ургуулжээ. Тэгээд тэд хүнийг бүтээжээ.

Анхандаа дэлхий гэж байсангүй. Агаар, ус хоёр л байжээ. Тэр цагт Очирваань бурхан тэнгэрт байсан юм байна. Тэр нэгэн удаа доошоо харж энэ их усны оронд газар дэлхий бий болгох юмсан гэж боджээ. Үүнийг хийхэд ганцаар хүчин хүрэхгүй, туслах нөхөр хэрэгтэй гэж бодоод хань хамсаа болох нөхөр эрж явсаар Цагаан Шүхэртийг олж авчээ.

Шарын бөөгийн ертөнц гурван давхаргаас бүрдэх ба ертөнц нь чанарын ялгаатай болж өөрчлөгдсөн нь харагддаг. Дээд давхарга нь ариун сайхан газар, буянтай ертөнц, дунд давхарга нь хүн амьтан амьдардаг, доод давхарга нь үхэл, өвчин эмгэгээр дүүрэн тамын газар юм.³²

Бурхны шашин дэлгэрснээр бөө мөргөлийн цуваа цэгийн харилцаанд ертөнцийг үзэх үзэл нь хам цэгийн харилцаанд ертөнцийг үзэх үзэл болон өөрчлөгдөж, тэнгэрийн дээд ертөнц нь бурхад амьдардаг, харин газрын доорх доод давхарга нь чөтгөрүүдийн амьдардаг далд ертөнц болжээ.³³ Түүнчлэн гурван ертөнцийн тухай үзэх үзэл нь илүү

нарийсаж, тэнгэрт 99 тэнгэр, газрын 77 бурхан, мөн газрын доор нь 7 буюу 77 давхраас бүрддэг болох нь тодорхой болжээ.

Уг нь Монголын бөө мөргөлд ердөө есөн бурхан байсан ч онгод тэнгэрийн тоо ихэссэн шалтгаан нь Төвөдийн бурхны шашны онгодтой зохицох буюу тэдний онгод бурхдыг хүлээж авснаас үүдэлтэй. Онгод дуудах бөөгийн зан үйлийг ч лам нар хийх болжээ.

3) Сүнс болон хойд насны талаарх үзлийн өөрчлөлт

Монголчууд хүнийг байгалийн нэг хэсэг гэж үздэг бөгөөд амьтан, ургамал, уул, хад зэрэг амьгүй биет, мөн байгаль дэлхийн ард үл үзэгдэх хүч оршино гэж боддог. Монголчууд хүний бодол санаа, хандлага байгальд нөлөөлж, зохих хариуг хүртдэг гэсэн байгаль, хүн хоёрын учир шалтгаан, үр дагаврын холбоотой хэмээн итгэдэг. Түүнчлэн байгальд онгод тэнгэрүүд хаа сайгүй оршдог тул эдгээр онгод, сүнс, эздийг шүтэн мөргөж, тахил өргөснөөр амьдрал эв найрамдалтай, эмх цэгцтэй болж, сэргэдэг гэж үздэг.³⁴

Мөн амьтан, хүн хоёр бие махбод, сүнс хоёрын нэгдэл бөгөөд бие махбод нь тодорхой хугацааны дараа үхдэг ч сүнс нь мөнх байдаг, амьд хүнтэй ижил шинж чанартай оршдог гэж үздэг. Хэдийгээр сүнсний хэлбэр дүрс нь хүний биетэй ижил төстэй боловч зүүд, зөгнөлөөр л харагддаг, энгийн үед харагдахгүй, биет бус агаар, амьсгалтай адил гэж үздэг. Сүнсийг мөн агаарт чөлөөтэй хөвж, цаг хугацаа болон орон зайд баригдалгүйгээр нөгөө ертөнц рүү аялдаг гэж үздэг.³⁵

³¹ И Анна (2010), 68.

³² Пүрэв.О. (2014) (2014), 70-71.

³³ И Анна (2010), 65.

³⁴ И Анна (2010), 2.

³⁵ Монголын бөөгийн шашинд мах цусны сүнс, ясны сүнс, тэнгэр сүнс гэсэн гурван зүйл бий. Мах цусны сүнс нь эхээс удамшдаг бөгөөд зүрхэнд үлдэж, үхэхэд алга болдог хязгаарлагдмал сүнс юм. Ясны сүнс нь эшгээс өвлөгдөж, хүний бүх ясаар дамжин оршдог, үхэхэд аарцаганд оршдог, 3 жилийн дараа түнхний яс алга болоход алга болдог хязгаарлагдмал сүнс юм. Сүүлийн тэнгэр сүнс эхийн хэвлийд байхдаа зүүн гарын бөгж хуруугаар нэвтэрч, тархи, нугасны гуурсаар насан туршдаа өнгөрч, нас барсны дараа яс нь алга

Дэлхийн бүх зүйлд сүнс оршдог гэдэгт Монголчууд итгэдэг. Зөвхөн хүн төдийгүй амьтан, чулуу, мод зэрэг амьгүй биетүүд сүнстэй, эзэнтэй гэж үздэг. Хэдийгээр бие нь үхсэн ч сүнс нь үлдэж, өөр амьтан болон дахин төрөх, эсвэл өвөг дээдсийн сүнс эсвэл өөр сүнс болж хувирдаг гэж үздэг юм. Гэвч харын бөө нь анхнаасаа хойд нас гэсэн ойлголтгүй байсан бөгөөд хүний үхэхдээ очдог хойд нас бол сүнс нь оршдог харанхуйн орон гэж ойлгодог байжээ.

О.Пүрэв “хүн үхэнгүүт амин сүнс үл үзэгдэх харанхуй орон руу гэрэлтэн нисэж, тодорхой хугацаанд байх бөгөөд энгийн хүний хувьд өөр хүний биед ордог. Харин бөөгийн хувьд онгод болж харанхуй орноос нарт хорвоод байдаг бүх хүмүүсийг хамгаалж асран хамгаалагч болдог”³⁶ гэж хэлжээ. Үүнээс үзэхэд бөө мөргөлд хүний сүнс нэг хүнээс нөгөөд шилжиж дахин төрдөггүй. Иймээс бөө мөргөл нь Буддын шашны амьдралын тойрог, хойд насны тухай үзэл санааг хүлээн зөвшөөрдөггүй бөгөөд энэ насны амьдралын ертөнцөөс өөр ертөнцийг огтхон ч үнэлдэггүй.³⁷

Монголын бөө мөргөл нь энэ насны амьдралын сайн муугаас үл хамааран хүн нас барахад сүнс нь харанхуй оронд байгаад хүний биед буцаж ирдэг гэж үздэг. Тэр дундаа талийгаачийн шарилд ул мөр үлдээвэл хожим дахин төрөхөд тэмдэглэгдсэн хэсэгт эсвэл нөгөө талдаа тэмдэгтэй төрнө гэж үздэг. Иймээс бөө мөргөл нь хүний сүнс өөр хүний сүнс рүү шилждэг гэж үздэг тул хүний хойд дүрийг хүлээн зөвшөөрдөг боловч хүний амьдрал эцэс төгсгөлгүй дахин төрдөг гэсэн ойлголтыг үгүйсгэдэг ажээ.

Бөө мөргөлийн магтаалыг харвал энэ насны аз жаргал, ерөөлтэй байхыг хүсэж бөө нараар бөөлүүлдэг байсныг харуулж байна.

Одноос олон малтай болтугай
Уулаас их цагаан гэртэй болтугай
Төрсөн бие чинь мөнх жаргах болтугай
Бурхан мэт буянтай болтугай
Буудай мэт малтай болтугай³⁸

Нөгөө талаар, бөө мөргөлд хүнээс ялгаатай хойд дүрийн хууль нь хүрдэггүй онгод ертөнцийг хэлдэг бөгөөд энэ нь мөнхийн тухай ойлголтыг үгүйсгэдэггүй гэсэн үг юм. Иймд монгол бөөгийн ертөнцийг үзэх үзэлд зуурдын болон мөнхийн ойлголтыг аль алиныг багтаасан гэж хэлж болно.

Уг нь бөө мөргөлд энэ ертөнцийг мөнхийн харанхуй ертөнцтэй харьцуулахад энэ ертөнц нь хүн амьтан түр амьдардаг гэрэлт хорвоо юм. Монголчууд оршуулахыг эрхэмлэдэг байсан, ба эртний Монголчууд хүн үхэхээрээ хаа нэгтээ явдаг гэж боддог байжээ. Эртний Монголд эзний морийг оршуулгын эд зүйл болгон тавьдаг байсан нь эзэн нь үхэгсдэд нүүж ирэхэд морийг унаж яваад үйлчилдэг гэж үздэгтэй холбоотой. Хойлголох ёс нь хүнийг нас барсны дараа сүнс нь энэ дэлхий дээрхийн адил амьдардаг хэмээх ертөнцийг үзэх үзлийн шинж чанарыг харуулжээ.³⁹

Гэвч бурхны шашин нэвтэрснээр сүнс болон хойд насны тухай ойлголтод өөрчлөлт оржээ. Хамгийн гол нь үйлийн үрийн тухай, хойд насны тухай, мөн хойд дүрийн тухай ойлголт зэргийг нэвтрүүлсэн явдал байв. Төвөдийн Буддын шашин Далай ламыг нирваанд хүрч чадсан ч амьтдыг аврахын тулд бодьсадва болсон “хойд дүр” гэж үздэг. Мөн энэ нь хүний сүнс хойд дүрээр дахин төрдөг, үхсэний дараах амьдрал байдаг гэдгийг баталж байна.

Бурхны шашны нөлөөнд автсан шарын бөө нь бурхны шашны хойд

болоход гэнгэрт гараад харанхуйн оронд үүрд оршдог. Иймээс хүний сүнс хоёр хязгаарлагдмал сүнс, нэг хязгааргүй сүнс гэж үздэг. Үүнд хойд дүрийн тухай ойлголт байдаггүй. (О. Пүрэв (2014), *Монголын бөөгийн шашин*, 133)

³⁶ Пүрэв.О. (2014), 363.

³⁷ Пүрэв.О. (2014), 137-138.

³⁸ Далай Ч. (1959), *Монголын бөөгийн мөргөл*, Уб, 37.

³⁹ И Анна (2010), 92-94.

насны тухай үзлийг хамгийн түрүүнд хүлээн зөвшөөрсөн ажээ. Тэгэхээр бөө мөргөлийн насны тухай үзэл нь урьд нас, энэ нас, хойд нас гэсэн гурван үзэлтэй болж, хүн энэ ертөнцөд үхэхдээ нөгөө ертөнцөд очно. Сайн үйл хийсэн сүнснүүд мөнх амьдрахын тулд диваажинд очиж жаргаж, харин муу үйл хийсэн сүнснүүд тамд очиж, бүх төрлийн шийтгэлийг үүрд хүлээн авдаг гэж үздэг байв. Иймд бурхны шашин нэвтэрсний дараа монголчууд хүн алахаас цээрлэж, энэ насандаа болж өгвөл өршөөнгүй амьдрах нь чухал гэдгийг ойлгожээ.⁴⁰

Хүн нас барахад сүнс нь бусдын биед орж, өмнөх насанд яаж амьдарсны үрээр дараагийн амьдрал нь сайн, муу үргэлжилж болно гэж боддог байжээ. Энэ нь Хүний амьдрал үйлийн үрээр тодорхойлогддог гэсэн бөөгийн үзлийг харуулж байна.⁴¹ Амьдралын сайн муугаас үл хамааран “хойд насны харанхуй ертөнцөд очно” гэж боддог бөөгийн үзэл бурхны шашны нөлөөгөөр ийнхүү өөрчлөгдсөнийг харуулж байна. Өмнө нь монголчуудыг оршуулах ёслолыг бөө нар зохион байгуулдаг байсан бол бурхны шашин нэвтэрсний дараа лам нар үйлдэж, тарни, уншлага номыг нь ч мөн өөрчилжээ.⁴²

Түүнчлэн Монголд “Тэнгэрийн оршуулга” үйлддэг байжээ. Тэр нь “үхэл бол амьдралын нэг хэсэг бөгөөд сүнсэнд амьдрал, үхлийн ялгаа байхгүй” гэсэн Буддын ертөнцийг үзэх үзлийн зан үйл юм. Хойд насны тухай үзэл ч гэсэн, бие нь байгальд буцаж, сүнс нь тэнгэрт хальж, дараа нь хүн, амьтны бие болон өөрчлөгддөг гэж үзэх болжээ.⁴³

⁴⁰ Пүрэв Отгоны (2001), 28.

⁴¹ Марко Поло (2006), *Дорнын аялын тэмдэглэл*, Ким Ху Дун ор., Сакежол, 291.

⁴² Монголчуудын оршуулгын зан үйлийн хамгийн чухал зан үйл бол Алтан сав нээх ёслол юм. Оршуулгын газар, цаг хугацаа, шарилыг авах, уншуулах ном судар, шарилыг гаргах зэрэг оршуулгын бүх зан үйл, үйл ажиллагааг тогтоодог ёслол бөгөөд үүнийг бурхны шашны лам хариуцдаг юм.

⁴³ И Анна нь “Хааны эрх мэдлийг нэгтгэсний дараа сүнс тэнгэрт гарах санаа, тэнгэрийг шүтэж санаагаар илүү хүчтэй болсон. Хүн үхэхдээ бурхан болсон гэдэг бөгөөд энэ нь эхлээд газартай холбогдож байснаа, дараа нь тэнгэртэй холбоотой хэрэглэгдэх болсон гэж тайлбарласан. (И Анна (2010), 97)

Дүгнэлт

Судлаач миний бие энэ судалгаандаа Төвөдийн Буддын шашин орж ирснээр монгол бөөгийн ертөнцийг үзэх үзэл хэрхэн өөрчлөгдсөнийг авч үзлээ.

Монголын бөө мөргөл нь өөрийн гэсэн өвөрмөц шинжийг хадгалахыг хичээсэн бөгөөд Төвөдийн бурхны шашны ертөнцийг үзэх үзлийн элементүүдийг өөртөө шингээж, нэгтгэх замаар өөрийн байр сууриа хадгалахыг хичээсэн гэж бид үзлээ. Түүнчлэн ертөнцийг хам цэгийн харилцаанд үзэх үзэл буюу гурван давхаргатай ертөнцийг үзэх үзлийг, тэр дундаа хүн төрөлхтний хойд насны тухай үзлийг ч хүлээн авчээ. Мөн бурхны шашны сонирхолтой өвөрмөц зан үйлийг оруулан ирж, Төвөдийн бурхдыг нэмэн шүтэж, диваажин, там, үхлийн дараах ертөнцийг мөн хүлээн зөвшөөрчээ. Гаднаас нь харахад, Монголын бөө мөргөл нь бурхны шашинд шингэсэн мэт харагдавч үнэндээ тасралтгүй үргэлжилсэн хавчлагын дунд бурхны шашны гадаад хэлбэрийг “өмсөж” амьд үлдэхийг л хүсэж байжээ. Ингэснээрээ бөөгийн ертөнцийг үзэх үзлийг хэвээр нь хадгалсаар ирсэн гэж тайлбарлаж болно.

Ном зүй

Монгол хэл дээр

1. Дамдинсүрэн.Ц. (1957), *Монголын уран зохиолын тойм*, Уб.
2. Ринчен. Б. (1959), *Монгол бөө мөргөлийн гарал үүсэл*, Уб.
3. Далай.Ч. (1959), *Монголын бөөгийн мөргөл*, Уб.
4. Пүрэвжав.С. (1978), *Монгол дахь шарын шашны хураангуй түүх*, Уб.
5. Дулам.С. (1989), *Монголын домог зүйн дүр*, Уб.

6. Дулам.С. (1992), *Монголын дархад бөөгийн уламжлал*, Уб.
7. Пүрэв.О. (2014), *Монгол бөөгийн шашин*, Уб: Монгол Улсын Шинжлэх Ухааны Академ.
8. Сүхбаатар.Г. (2000), *Монголын эртний түүх судлал*, Уб.
9. Сүхбат.Ш. (2007), *Бөө II хэвлэл*, Уб.

АНГЛИ БОЛОН СОЛОНГОС ХЭЛ ДЭЭР

1. Charles. Kraft. (2008), *Worldview for Christian Witness*, Pasadena, CA: William Carey.
2. 강틀가 외 (2009), 『몽골의 역사』, 김장구, 이평래 역, 서울: 동북아역사재단.
3. 발터 하이시히 (2003), 『몽골의 종교』, 이평래 역, 서울: 소나무.
4. 박원길 (1998), 『북방민족의 샤머니즘과 제사습속』, 국립민속박물관.
5. 이동주 (2005), 「티베트불교 연구」, 『신학과 선교』 제 7 호, 서울신학대학교.
6. 이안나 (2010), 『몽골의 민간신앙 연구』, 서울: 한국문화사.
7. 이승훈 (2021), 『몽골세계관과 세계관의 변혁』, 울란바토르.
8. 고려대민족문화연구원 (2001), 『몽골의 무속과 민속』, 월인.
9. 장장식 (2002), 『몽골 민속 기행』, 자우출판.
10. 체렌소드눔 (2001), 『몽골민간신화』, 이평래 역, 대원사.
11. 마르코폴로 (2006), 『동방견문록』, 김호동 역. 사계절.
12. 안점식 (2008), 『세계관 종교 문화』, 죠이선교회출판부.
13. 텀베렐 (2019), 「몽골의 티베트불교 수용에 따른 종교와 사회변화 고찰」, 『선문화 연구』 27 권, 한국불교선리연구원.
14. 박환영 (2013), 「몽골샤머니즘 속의 윤리의식 고찰」, 『중앙아시아연구』 제 18 권, 중앙아시아학회.

15. 박환영 (2015), 「몽골샤머니즘 속 불교의 수용 양상 고찰」, 『몽골학』 41 호, 한국몽골학회.

Abstract: *Mongolians have been worshipping shamanism since the time of the clan society. However, Mongolian shamanism gradually changed its worldview as it experienced religious conflicts due to the two influx of Tibetan Buddhism after the Mongol Empire period and the active missionary policy.*

In the view of god, the gods of Tibetan Buddhism were accommodated in shamanic blessing songs and rituals. In the view of the universe(nature), the gods of Tibetan Buddhism were added or replaced as creators, and the traditional horizontal worldview was changed to a vertical worldview with qualitative differences. In the view of life and the soul, the concept of causality and retribution according to good and evil, reincarnation in the afterlife, and the Buddhist concept of reincarnation were added. And the Buddhist view of life, the three lives of the past, this life, and the afterlife, influenced the Mongolian people's view of salvation and practical behavior as they had a world view that future destiny is related to present life.

Mongolian shamanism tried to maintain its belief by disguising itself by partially accommodating the religious and worldview elements of Tibetan Buddhism while retaining the unique characteristics of shamanism. The spread of Tibetan Buddhism in Mongolia narrowed the position of shamanism, but it was not absorbed or incorporated into Tibetan Buddhism or disappeared. Rather, shamanism achieved religious incorporation through mutual influence with Tibetan Buddhism. So, outwardly, shamanism was dominated by Tibetan Buddhism, but on the inside, it took on the aspect of religious syncretism through acceptance and fusion.